

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-12
<hr/>	
1.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-12

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 02-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 55 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ж.Ганбаатар, Г.Дамдинням, З.Мэндсайхан,
Д.Пүрэвдаваа;
Эмнэлгийн чөлөөтэй: Г.Ганбаатар.

**Нэг.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэрүүн дэд дага Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн нар хариулж тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Мөнхсоёл, Б.Заяабал нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 4

Бүгд: 19

78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 25 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН
02-НЫ ӨДӨР /ДАВАА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Даваасүрэн: Байнгын хороонд ирвэл зохих 25 гишүүнээс 14 ирсэн ирц 56 хувьтай байна. Би ирцийг та бүхэнд танилцуулъя.

Т.Аубакир гишүүн ирсэн байна, Ж.Батжаргал гишүүн ирсэн байна, Ц.Даваасүрэн гишүүн ирсэн байна, П.Мөнхтуяа гишүүн ирсэн байна, Д.Цогтбаатар гишүүн ирсэн байна, Д.Батбаяр гишүүн ирсэн байна, Х.Болормаа гишүүн ирсэн байна, Б.Заяабал гишүүн ирсэн байна, Г.Тэмүүлэн гишүүн ирсэн байна, Б.Чойжилсүрэн гишүүн ирсэн байна, Р.Батболд гишүүн ирсэн байна, П.Ганзориг гишүүн ирсэн байна, Б.Мөнхсоёл гишүүн ирсэн байна, Б.Банзрагч гишүүн ирсэн байна.

Өнөөдрийн хуралдааны ирц 56 хувьтай байгаа учраас хуралдааныг эхэлье ээ.

2024 оны 12 сарын 2-ны өдрийн хуралдаан эхэлснийг мэдэгдье ээ. Байнгын хорооны хуралдаанаар танилцуулах асуудлыг би та бүхэнд танилцуулъя.

Нэг асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байна. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн. Сайд байгаа юм уу? Сайд танилцуулга хийнэ дуудаарай.

Болдын Жавхлан Сангийн сайд, Б.Солонгоо ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Ж.Ганбат Сангийн яамны ТНБД, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга З.Энхболд, Сангийн яамны Хууль зүйн газрын дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Жавхлан сайд танилцуулга хийе.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлж Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомжид 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээж авсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний нэгдсэн чуулганаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсан.

Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан төсвийн цаглаврын дагуу жилийн төсвийн төслийг Засгийн газар 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг 11 сарын 15-ны дотор батлахаар тус тус заасан байдаг. Харин Улсын Их Хуралд улсын төсөв, ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, ЭМД-ын сангийн төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газраас төсвийн төслийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх тусгайлсан зохицуулалт байхгүй тул уг харилцааг зохицуулсан хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар жилийн төсвийн төслийг Засгийн газар дахин боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх эрх зүйн орчин бүрдэх юм аа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайдад баярлалаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд байна уу? Тэмүүлэн гишүүнээр тасалъя.

Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Тодорхой нэг их асуух ч асуулт алга даа. Би зүгээр яах вэ ерөнхийдөө орж ирж байгаа Төсвийн тухай хууль дээр оруулж байгаа нэмэлт өөрчлөлт дээр тодорхой зүгээр саналаа л хэлье гэж бодоод байгаа юм. Энд нэг анхаарах ёстой 2 асуудал байгаа болов уу л гэж бодож байна.

Нэгдүгээрт нөгөө аймаг, орон нутаг, энэ аймаг, нийслэл, сум дүүргийн төсөв хэлэлцэн батлах хугацаатай холбоотой асуудал байгаа. Тэгээд яах вэ энэ томьёоллоороо орж ирснээрээ бол дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө буюу 12 сарын гучныг ингэж оруулж өгөөд байгаа. Тэгэхээр би энэ хугацаан дээр бол бид нар бас нэг талдаа яг ингэж хатуу хугацаа тавих шаардлага байна уу үгүй юу? Энэ дээр бол нарийвчилж зүгээр оруулж өгөх зохицуулалт нь бол одоо Улсын Их Хурал

улсын төсвийг хэлэлцэн баталснаас хойш гэдэг юм уу хэлэлцэн батлаад хүчин төгөлдөр болсноос хойш гээд тэгээд тэрнээс хойш магадгүй нэг юу гэдэг юм 10 хоног гэдэг юм уу, 5 хоног гэдэг юм уу, 7 хоног гэдэг юм уу тийм хугацаа бол тавьж өгөх нь зөв байх. Тэгээд магадгүй сумыг ч гэсэн сум дүүргийг бол бас магадгүй юу Аймаг, нийслэл хэлэлцэн батлаад тухайн тэр төсөв хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоногийн дараа гэдэг юм уу нэг тиймэрхүү хугацаа тавьж өгвөл зөв болов уу л гэсэн юу байна. Тэгэхээр яах вэ зүгээр амьдрал өөрөө баян учраас бид нар бас энэ тусгайлсан заалт зохицуулалт байхгүй зүйлүүдийг тодорхой болгож байгаа. Тэгээд энийг бол дараа дараадаа ч гэсэн зөвхөн энэ жил биш дараа дараагийн жилүүдэд хэрэгжүүлэх ийм зохицуулалтуудыг бас зөв байдлаар тавиад явбал зүгээр юм уу л гэсэн ийм бол 1 дүгээрт саналтай байгаад байгаа юм. Тэгэхээр хууль хүчин төгөлдөр болсноос хойш гэж нэг хоног тавих нь зөв байх гэсэн. Энийг бол манай бас Тамгын газрынхан маань Байнгын хорооны референтүүд маань бас энийг бас нэг анхаарч үзээрэй гэсэн ийм 1 дүгээрт саналтай байгаад байгаа.

Хоёрдугаарх нь яах вэ энэ 32^{1.1} дээр хүчингүй болгосон гэж байгаа юм. Хуульд тухайн Төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол гэж заагаад байгаа тиймээ.

Тэгэхээр хүчингүй болгосон гэдэг ганцхан зохицуулалтыг бас энд нарийвчилж зааж өгөх нь юу юм бол. Бусад юу гэдэг юм буцаасан ч гэдэг юм уу өөр бас нэг үүд хаалга бас онгорхой үлдчих вий дээ. Дараа нь дахиад нэг бас дараа дараагийн юу гэдэг юм асуудлууд үүслээ гэхэд дахиад нэг энэ хууль дээр хөн хөндөөд байх энэ заалтаа яриад байх шаардлагагүйгээр л нэг мөр уг нь бол зохицуулалтыг хийх нь зөв болов уу л гэсэн нэг ийм саналтай байгаа. Тэгээд энийг бас нэг хэлэлцүүлгийн явцад анхаарч үзээрэй л гэсэн саналыг хэлж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Тэр эхнийх дээр нь Жавхлан сайд нэг жоохон тодруулга өгчихье.

Одоо ингээд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулиар бол иргэдийн хурал төсвөө хугацаандаа батлаагүй бол тарна гэсэн заалттай учраас ондоо багтана гэдэг тэр 32^{1.5} дахийг хэлээд байх шиг байна. Тэгээд энд та нар багтана гэж тооцсон үндэслэлээ нэг тайлбарлачхаач?

Б.Жавхлан: Тийм. Энэ жилийн хувьд 11 сарын 8-нд батлагдсан Ерөнхийлөгчийн хоригийн хугацаанд хориг тавигдсан. Хэлэлцээд төлөвлөх шатандаа Засгийн газар төлөвлөх нь зүйтэй юм гээд ингээд хуулийг буцаасан. Х. Тал талаас нь л ярьсан юм. Эхлээд хугацаа заачихъя гэж бас бодож байсан юм. Одоо юу гэдэг юм энэ жилийн ядаж календарийг харахад 12 сарын 13-ны дотор батлаад улсын төсвөө батлаад тэгээд дараа 7 хоногт нь 20, 25 гээд 2 хугацаа заах уу гээд. Тэгээд заачихаар бас хугацаандаа таарахгүй байвал яах вэ? Бас ингээд хэрэв үнэхээр төсвөө аятайхан баталчих юм бол дараагийн орон нутгийн төсөв чинь үндсэндээ бэлдчихсэн байгаа юм чинь 1, 2 хоногийн дотор батлаад явчих ч бас ийм боломжууд байгаа.

Тэгэхээр задгай ингээд, задгай ч юу байх вэ дээ ингээд бүгд ер нь хүссэн хүсээгүй дараалал бол улсын төсөв батлагдсанаас хойш л нөгөө аймаг сумынх чинь явна шүү дээ. Тэгэхээр яах вэ тэнд дарааллын тавих биш тэр нь ойлгомжтой юм чинь хамаагүй хугацаа тавьчихаар хугацаандаа бас шахагдаж амжихгүй бол бас яах вэ гэдэг эрсдэл байгаа учраас тэр үед нь дахиад л хуулиа өөрчлөөд л хэдүүлээ

хугацаагаа өөрчлөх бас иймэрхүү асуудал үүсэж болзошгүй учраас ингээд ондоо багтаагаад гэдэг ерөнхий цаглавраар явчих нь л зөв юм болов уу л гэж харсан.

Ц.Даваасүрэн: Ондоо багтаагаад гэдэг чинь энэ хугацаа болчихоод байгаа байхгүй юу. Тийм. Тэгэхээр ондоо багтахгүй болчихоор нөгөө Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийн 36-аар иргэдийн Хурал чинь тарах нөхцөл байдал үүсчих гээд байна л даа.

Б.Жавхлан: Энэ цаглавраар ч тийм байдал үүснэ. Хуучнаараа ч тийм байдал үүснэ. Тэгэхээр хэдүүлээ ондоо багтаагаад л ингээд л аль шат шатныхыг нь явуулчихъя л гэж байгаа юм. Гагцхүү би Тэмүүлэн гишүүний асуултад бол ингэж л хэлэх гээд байгаа байхгүй юу. Дарааллын хувьд бол хүссэн хүсээгүй улсын төсөв эхэлж батлагдаж байж нийслэл, аймаг, дараа нь сум, дүүргийнх хэлэлцэж таарна.

Дээд шатных нь төсөв батлагдах уу? Доод шатных нь төсөв хэлэлцэх боломжгүй учраас, 1 дүгээрт.

Хоёрдугаарт, хугацаа тавьчихаар хугацаандаа шахагдаад багтахгүй эхний дээд талын шатнуудынх нь хугацаандаа багтахгүй болчихвол бас дахиад дэгээ өөрчлөх л нэг ийм л юм болчих вий л гэж бодоод байхгүй юу. Тэгж бодсон юм ингээд тал талаас нь л харсан юм. Тэгээд энэ нь байж болох хувилбар юм уу даа л гэсэн юм.

Ц.Даваасүрэн: Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Нэгдүгээр асуулт ер нь санал сая давхардчихлаа. Цаг хугацааныхаа хувьд яах вэ гэж байсан юм.

Хоёрдугаар асуулт нь Засгийн газар Яг цаг хугацаандаа 2025 оны төсвийг өргөн барьсан Улсын Их Хурал бас яг цаг хугацаанд нь төсвийн төслийг баталж хууль болгож гаргасан.

Гуравдугаарт бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхийлөгч хориг тавьсан. Тэгээд энэ хоригтой холбоотой асуудал дээр бид нар орж ирээд дэг дээр ямар нэгэн хоригийг хүлээж авсан тохиолдолд яах вэ гэдэг гарц гаргалгааныхаа хувьд байхгүй учраас одоо бид нар ингээд төсөв дээрээ нэлээн цаг алдах нөхцөл байдал руу орчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ Ерөнхийлөгчийн дэгтэй холбоотой нарийвчилсан зүйл заалтуудыг дахиж яг эндээ цуг оруулж ирээд шийдүүлээд явчих боломж бас байх уу л гэж асуух гэсэн юм. Ерөнхийлөгчийн дэгтэй холбоотой үйл ажиллагаагаа илүү нарийвчилж оруулж ирээд хориг тавьсан тохиолдолд ингэж ингэж хэлэлцэнэ гэсэн ийм дэгийн зүйл заалтуудаа оруулж ирээд явахгүй бол бид нар чинь сая Ёс зүй, дэгийн байнгын хороон дээр нэг дэг хийх гэж үзээд тэр нь уначихлаа. Тэгээд одоо дахиад нэг гарц хайгаад яваад байна шүү дээ.

Тэгэхээр өмнөх Ерөнхийлөгчийн дэгтэй холбоотой нарийвчилсан зүйл заалт байна уу гэж. Энэ дээр байна шүү дээ оруулж ирж болох уу гэж.

Ц.Даваасүрэн: Одоо энэ нөгөө төсөв чинь хүчингүй болчихсон учраас ахиад төсвийн төсөл шинээр өргөх гэж байгаа байхгүй юу. Шинээр өргөсөн тохиолдолд яах вэ нөгөө төсөв хэлэлцдэг цаглавраараа л явна нөгөө 4 хэлэлцүүлгээрээ л явна. Зүгээр яах вэ ганц зохицуулалт гарч ирж болзошгүй.

Яагаад гэвэл одоо ингээд цаг хугацааны хайчинд шахагдчихаад байна шүү дээ. Одоо багтааж байна. Тэгэхээр нөгөө Төсвийн тухай хуулиар чинь нөгөө 5 хоногийн зайтай хэлэлцүүлгийг хийхээр хуульчилчихсан байдаг байхгүй юу. Тэгэхээр энийг л нэг жоохон нэг удаагийн горимоор ч юм уу яаралтай байдлаар 5 хоног хүлээхгүйгээр хэлэлцэхгүй бол орон нутгийн шат шатны аймгийн сумдын төсвүүд хугацаандаа батлагдахгүй улмаар нөгөө тэр Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийнхаа 36-аар иргэдийн хурлууд тарах нөхцөл байдлууд үүсчих гээд байгаа учраас нэг ийм цаг хугацааны асуудлыг зохицуулах дэг байгаа. Бусад нь яг л нөгөө төсвөө хэлэлцдэг, дэгээрээ явна. Айн шаардлагагүй л дээ. Хариул хариул.

Б.Жавхлан: Энэ Цогтбаатар Засгийн газар руу буцаалгүйгээр Их Хурал хоригийг хүлээж аваад тэндээ хэлэлцчихдэг тэгж асуугаад байна. Тийм дэг тийм горимын хуулийн зохицуулалт оруулж ирэхгүй юм уу гэж асуугаад байгаа юм. Тэгэхээр тэр яг үнэхээр яг үнэн. Ингээд онгорхой үлдчихэж байгаа байхгүй юу. Яах вэ тэрэн дээр 2 хэсэг л болоод байна л даа. 90.8, 90.9-өө энэ чинь ойлгомжтой болж байна шүү дээ. Энүүгээрээ хоригоо хүлээж аваад Их Хурал дээрээ хэлэлцээд явчих боломж байна гэсэн нэг хэсэг байна. Нэг хэсэг нь энэ нь бас дутуу юу эрх зүйн чадамж нь сул байна гэсэн ийм 2 хэсэг болчихоод байна. Энэ удаа бол Их Хурал буцаачихсан тохиолдолд Засгийн газар яаж эргэж өргөн барих вэ гэдэг тэрийгээ хуульчилж байгаа ийм зохицуулалт. Тэгэхээр яг тэр Цогтбаатар гишүүний ярьдаг тэр бол тэрийг бас нэг тийш нь болгоод зохицуулалт хэрэгтэй л юм байна лээ.

Ц.Даваасүрэн: Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авбал хоёрхон тохиолдол байгаа шүү дээ. Нэгд хүчингүй болгоно, хоёрт нэмэлт, өөрчлөлт оруулна.

Нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийг Байнгын хороо санаачилна гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр төсөв дээр нэмэлт, өөрчлөлт гэдэг чинь тодотгол.

Тэгээд л энэ тодотголын хэмжээний одоо төслийг Засгийн газрын оролцоогүйгээр Төсвийн байнгын хороо санаачлаад хэлэлцүүлнэ гэж боломжгүй зүйл байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ энийг нэг хуулиараа ер нь төсвийг яаж хэлэлцэх юм. Зүгээр ердийн хууль дээр бол нэмэлт, өөрчлөлт хийгээд л явчих юм байна лээ л дээ хориг хүлээж авсан тохиолдолд.

Тэгээд энэ 2-ыг бас цаашдаа бол салгаж зохицуулах ийм шаардлага байх шиг байна аа.

Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Хуулийн төсөлтэй холбогдуулаад Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Хуулийн төслийг дэмжиж байна.

Зүгээр ер нь саяын Ерөнхийлөгчийн тавьсан хориг бүхэлд нь тавьчихсан. Тийм учраас энэ хүчингүй болгож шийдэх нь зөв байсан. Бид бол тэгж ойлгосон.

Тийм учраас дахин өргөн барих шаардлага гарч ирж байгаа юм. Хэсэгчлээд хориг тавьчихсан бол төсөв дээр энэ нэмэлт, өөрчлөлт байхгүй юу.

Тийм учраас мөн дахин өргөн барих тухай асуудал яригдана. Тийм учраас би Төсвийн тухай хуульдаа ийм байнгын шинэ зүйл нэмж байгаа нь зөв юм байна ийм нөхцөл шинэ нөхцөл байдал үүсвэл яг энэ харилцаагаараа төсвөө өргөн барьдаг ийм нөхцөл бүрдэх юм байна гэж ингэж харж байгаа. Тийм учраас дэмжиж байна гэж.

Ер нь бол анхны хэлэлцүүлгийн үе дээр бол 5 дахь заалтыг бид тал бүрээсээ ярилцаж энэ Их Хурлын хуулийн газар энэ тэрээсээ тодруулга юмнуудаа нарийсгаж авч энэ 32¹-ээр өргөн барьсан асуудлыг Их Хурал хэд хоног дотор багтааж хэлэлцэж батлах ёстой юм бэ? Их Хурал улсын төсөв баталчихсанаас хойш хэд хоногийн хугацаанд багтааж аймаг нийслэл төсвөө баталсан байх ёстой юм. Аймаг нийслэлийн төсөв батлагдсанаас хойш хэд хоногт багтааж сум, дүүрэг төсвөө батлах юм гэдгийг хоногоор нь цагалбаржуулж өгөх хэрэгтэй болчихоод байгаа юм. Тэгж байж сая энэ хуулийн шаардлага хангагдана.

Зүгээр энэ хууль үйлчлээд явахаар зэрэг тэр таны хэлээд байгаа засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжид байж байгаа тэр заалт хэрхэн хангагдаж болж байна уу, үгүй юу гэдгийг манай хуулийн талынхан бас анзаарах ёстой ингэж байж энэ хууль хоорондын нийцэл хангагдах болов уу гэсэн бодол байна. Тийм учраас би анхны хэлэлцүүлгийн үеэр энүүнийг нэг тодруулж гаргаж өгөөрэй гэж хэлэх гээд байна аа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Одоо ингээд Батжаргал гишүүний хэлж байгаа шиг бид нар ингээд цаглавруудыг маш нарийн үзэхгүй бол болохгүй. Одоогийн энэ орж ирж байгаа Төсвийн тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийг хүртэл хүчин төгөлдөр болох энэ процессыг хүртэл сайн тоолох хэрэгтэй. Ерөнхийлөгчийн хориг хүчин төгөлдөр болох гээд ингээд тэрний дараа нь ахиад өргөн барих энэ процессуудыг ингээд нарийвчилж сайн тооцохгүй бол ондоо багтаагаад сумын ИТХ-ыг төсөв батлагдчихаад байна шүү дээ. Тэгээд энэндээ багтахгүй нөхцөл байдал үүсвэл Сумын иргэдийн Төлөөлөгч хүртэл тарна. Тийм учраас энэ бүгдийг хэдүүлээ сайн анхаарч ингэж явахгүй бол бид нар ерөөсөө 34 жилд байхгүй ийм тохиолдол руу ороод л тэгээд өөрсдөө ийм юу хүнд байдал руу орчихлоо л доо.

Тийм учраас яаж орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудыг хугацаанд нь төсвөө батлуулах вэ гэдэг энэ цаглаврыг бодолцож хэдүүлээ энэ төсвийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах ийм шаардлага үүсэж байна гэж.

Мөнхсоёл гишүүн үг хэлье.

Б.Мөнхсоёл: Саналын хэсэг явж байгаа тиймээ? Би зүгээр ингэж хэлэх гэсэн юм. Манай гишүүдийн хэлж байгаачлан энэ бараг өдөр тутамдаа чуулган болгонд шинэ шинэ асуудал гарч ирээд байна шүү дээ. Монгол Улсын хувьд бас энэ төсвийн асуудалтай холбоотой ийм сургамжтай, ийм үйл явдлууд удаа дараалан болж байна аа. Тэгэхээр өнөөдөр бид нар энэ давчуу цаг хугацаанд хамгийн гол нь ирэх оныхоо төсвийн тухай хуулийг батлах дээрээ анхаарах цаг нь болсон юм болов уу. Тэрнээс биш энэ төсөвтэй, төсвийг дагалдаж орж ирж байгаа хуулиудтай холбоотой асуудлуудыг цаашдаа цогцоор нь шийдэхгүй бол ерөнхийдөө болохооргүй болчихжээ. Тэрийг бол ирэх оныхоо Төсвийн тухай хуулийг баталсныхаа дараа бүр

ингээд тусгайлан ажиллах хэрэгцээ шаардлага өндөр байна гэдгийг хэлмээр байгаа юм аа.

Одоо ирэх оныхоо Төсвийн тухай хуулийг яг нөгөө анх төсөв өргөн баригдсанаас хойш явдаг дэгийнхээ дагуу явах тул өөрөөр хэлэх юм бол төсвийг хэлэлцэх 4 үе шат дамжина.

Тэгэхээр энэ цаг хугацааг аль болохоор компакт нь ингээд нягтаршуулаад хугацааг нь ойртуулаад, манай гишүүд ялангуяа манай энэ Байнгын хорооны гишүүд маань бүүр нэг нягт суугаад цаг хугацааг хожих маш сайн чанартай хэлэлцүүлэг өрнүүлэх мэтгэлцэх цаг болсон юм болов уу гэж хараад байгаа юм аа.

Тэгэхээр энэ асуудлыг эрэмбэлэх дээр л санал оруулж байна гэсэн үг шүү. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Заяабал гишүүн. Гишүүд ээ ер нь яг ингээд үг хэлэх асуулт асуух санал авч байх хугацаанд нь саналаа өгөхгүй бол бас жоохон зөрчигдөх байдалд орчхоод байна шүү. Заяабал гишүүн.

Баярлалаа. Тэгэхлээр би өнөөдрийн энэ үүсээд байгаа асуудалтай холбоотой бас санал гаргах гээд байгаа. Одоо нэгэнт энэ Төсвийн тухай хууль дээр өөрчлөлт орж байгаа дээр бас нэг өөрчлөлтийг оруулбал яасан юм бэ гэдэг л ийм л санал гаргах гээд байгаа юм. Яагаад гэхээр өнөөдрийн энэ үүсээд байгаа асуудал бол яг энэ сонгуулийн жилтэй холбоотой сонгуулийн дараах шинэ Засгийн газар бүрдсэнтэй холбоотойгоор үүсэж байгаа асуудал гэж ингэж харж байгаа. Сонгуулийн дараа шинэ Засгийн газар бүрдээд шинэ Засгийн газар маань бүрдсэнтэй холбоотойгоор өнгөрсөн 7 сард нэлээдгүй бас ажилтай, нэлээдгүй ачаалалтай ажилласан. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, төсвийн тодотгол, төсвийн гүйцэтгэл гэх мэтчилэн ингээд маш олон бодлогын баримт бичгүүд дээр ажилласан. Ингээд 8 сард тэрийгээ Улсын Их Хуралд өргөн барьсан.

Ингээд энд 7, 8 сар тэр чигээрээ ингээд ачаалалтай Засгийн газар маань ажиллаж байгаад шинэ хуулийн Төсвийн тухай хуулийн дагуу 9 сарын 1-нд дахиад дараа жилийнхээ төсвийг өргөн барих ийм болчхоод байгаа юм. Тэгээд эндээс холбоотойгоор би юу гэж ярих гээд байгаа юм гэхээр зэрэг энэ Засгийн газар яг дөнгөж байгуулагдаад өргөн барьсан төсвийн төсөл дээр бол маш их том бодлогын өөрчлөлтүүд оруулж ирсэн, бодлогын өөрчлөлтүүд оруулж ирсэн. Сангийн бодлого дээр нэлээдгүй том өөрчлөлт оруулж ирсэн. Орлогын, зарлагын, тэнцлийн гэх мэтчилэн нэлээдгүй өөрчлөлт оруулж ирсэн.

Дээрээс нь төсвийн гүйцэтгэл сайн байсантай холбоотой төсвийн орлого, зарлага аль алийг нь нэмэгдүүлж тодотголоор оруулж ирж өгсөн байгаа. Бид нарын өнөөдрийн үүсээд байгаа асуудал яг эндээс эхлэлтэй л гэж би ингэж харах гээд байгаа юм. Эндээс эхлэлтэй гэж харах гээд байгаа юм. Тийм учраас бол бид нар цаашдаа энэ Төсвийн тухай хуульдаа өөрчлөлт оруулаад сонгуулийн дараа төсвийн тодотгол хийхээр бол төсвийн ерөнхийлөн захирагч хооронд нь төсөв шилждэг ийм харилцааг л төсвийн тодотголоор оруулж ирж өгдөг. Ийм харилцааг бас энэ төсвийн тухай хууль дээр нэмэлтээр оруулж ирж өгвөл ямар вэ гэсэн ийм саналтай байгаа юм аа. Мөн төсвийн тодотголоо дагаад бид нар энэ төсвийн хүрээний мэдэгдлийг бас оруулж ирж байгаа.

Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол дунд хугацааны төсвийн бас тогтвортой байдлыг хангадаг. Бизнесийн, нийгмийн энэ бас тогтвортой байдлыг хангадаг ийм хамгийн гол зүйл. Ингээд төсвийн тодотголыг дагаад төсвийн хүрээний мэдэгдлийг бас давхар өөрчлөлт оруулж ирж байгаа юм. Энэтэй холбоотойгоор нөгөө нэг орлого, зарлага нэмэгдэх асуудал бас дахиад давхар боломжийг нь бий болгоод өгчхөж байгаа юм. Ингэхээр би юу гэж ярих гэж байна гэхээр зэрэг Мөн Төсвийн тухай хуульдаа өөрчлөлт оруулаад төсвийн хүрээний мэдэгдлийг зөвхөн дайн байлдаан ч гэдэг юм уу онцгой нөхцөл байдал үүссэн эсвэл төсвийн орлого биелэхгүй байгаа ийм яг нөхцөл байдал дээр тодорхой нэг 2, 3 нөхцөл байдал дээр төсвийн хүрээний мэдэгдэл дээр өөрчлөлт оруулж ирдэг ийм харилцаануудыг бас хуульд оруулж ирж өгөх шаардлага байна гэж ингэж харж байгаа. Ингэхгүй бол манай энэ төсвийн асуудал цааш цаашдаа сонгуулийн жилийн дараа давтагдаад авах бас ийм боломж байна уу боломж бас үүсэхээр байна уу гэж ингэж харж байгаа. Бид нар нэг удаа нэг асуудлыг шийдэх биш углуургаар нь уг сууриар нь асуудлыг шийдэх ийм шаардлагатай байгаа гэж ингэж харж байгаа.

Тийм учраас төсвийн тухай хуулийг орж байгаа энэ үед нь саяын 2 заалтыг нэмж оруулах бас ийм санал гаргаж байна аа. Шаардлагатай бол зарчмын зөрүүтэй санал гаргаад гишүүдээс санал хураалгаад явах ийм сонирх саналтай байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Заяабал гишүүн ээ одоо төсвийн тодотгол хийх 5 шаардлага байгаа. Төсвийн хууль дээр байж байгаа. Тэрний нэг нь гол шаардлага бол төсвийн ерөнхийлөн захирагч хороонд төсөв шилжүүлэх бол гээд нэг заалт мөн байхгүй юу. Тийм учраас таны хэлээд байгаа тэр орлого мөн ялгаа байхгүй бүгд байж байгаа.

Таван нөхцөл үүсэж байж төсөв тодотгох нь гэсэн дээр бүгд байгаа.

Хоёрдугаарт байна аа нэмэлт, өөрчлөлт дээр бол хөндөөгүй асуудлыг гаргаж болдоггүй шинэчилсэн найруулга юм уу аль эсвэл шинэ хуулийн төсөл дээр болдог учраас бид нар энэ удаа бол яг энэ хөндсөн асуудлаас өөр асуудлыг хөндөх бололцоогүй гэдгийг хэлье.

Ингээд гишүүд үг үг хэлж дууслаа. Дэгээрээ явъя.

Ингээд санал хураалт явуулж эхэлье гишүүд ээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 19 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 78.9 хувиар дэмжигдлээ.

Хэн хэн гишүүн байна аа. Баясгалан гишүүн, Батжаргал гишүүн, Батбаяр гишүүн. Энэ 3 гишүүний саналыг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг танилцуулчих уу? Ганхуяг гишүүн танилцуулъя.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлаар хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Тэгэхдээ манай Тамгын газрынхан бас нэлээн анхаараарай. Би түрүүн эхэнд хэлсэн. Цаглавруудыг их нарийн үзэхгүй бол болохгүй нь гэж. Энэ хууль одоо Ерөнхийлөгчийн хоригийн хугацаа хүчин төгөлдөр болох хугацаа гээд ингээд энэ зохицуулалтуудыг үзэхээр энэ 7 хоногтоо өргөж амжих уу үгүй юу гэдгийг их сайн тооцохгүй бол дараа дараагийн хуулийн зөрчил үүсээд явах вий гэдэг дээр манай Тамгын газрынхан анхааралтай хандахыг хүсье ээ.

Ингээд Төсвийн байнгын хорооны өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан дууссаныг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ.

15.20 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА